


Манай орны 10 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар -3°C (48.2°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар $+3.1^{\circ}\text{C}$ (53.8°F) –аас $+12^{\circ}\text{C}$ (66.2°F), бусад нутгаар -3.1°C –аас $+3^{\circ}\text{C}$ (48.4°F –аас 53.6°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 10 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3.2 хувь нь ордог. Тус сард нутгийн хойд, төв болон зүүн хэсгээр 5.1-18 мм, бусад нутгаар 0.3-5 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт


2025 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -4.5°C -аар, ОЖД-аас -2.9°C -аар тус тус хүйтэн байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 6 дахь хүйтэн сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 97.7% нь дунджаас -1.1 -ээс -6.1°C -аар хүйтэн, үлдсэн 2.3% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 6.3 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 43.2%-иар, ОЖД-аас 0.5%-иар бага буюу дунджийн орчим хур тунадас орсон. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 34.9% нь дунджаас ахиу, 10.1% нь дунджийн орчим, 55%-д дунджаас бага хур тунадас орсон байна.




Зураг 2. 2025 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 10 дугаар сарын агаарын температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар сарын ихэнх хугацаанд буюу 1 дүгээр 10 хоногийн дундаас 3 дугаар 10 хоногийн дунд үе хүртэл ОЖД-аас -0.5°C -аас -13.0°C -аар хүйтэн байсан бол бусад хугацаанд агаарын температур ОЖД-аас $+0.5^{\circ}\text{C}$ -аас $+8.8^{\circ}\text{C}$ -аар дулаан байлаа. Хур тунадасны хувьд 2 дугаар 10 хоногт нийт нутгаар харьцангуй ахиу, бусад хугацаанд бага хур тунадас орсон байна.



Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард температурын үнэмлэхүй их утга Баянхонгор аймгийн Шинэжинст суманд /Эхийнголд/ агаар $+28.2^{\circ}\text{C}$, хөрсний гадарга дээр $+44^{\circ}\text{C}$ хүрч халсан бол үнэмлэхүй бага утга Хөвсгөл аймгийн Хатгал суманд агаарт -30.9°C , хөрсний гадарга дээр -33°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Завхан аймгийн Баянтэс суманд 2-ны өдөр 11.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 966.8гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 766.0гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтай аймгийн Бугат суманд 32м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд